



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 202


Улаанбаатар
хот

Аргачлал батлах тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.9-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Нээлттэй өгөгдлийн төлбөр тооцох аргачлал”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Цахим хөгжил, харилцаа холбооны
сайдын үүрэг хариуцагч

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Л.ЭНХ-АМГАЛАН



Засгийн газрын 2022 оны 202 дугаар
тогтоолын хавсралт

НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ТӨЛБӨР ТООЦОХ АРГАЧЛАЛ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ аргачлалыг Засгийн газраас баталсан нээлттэй өгөгдлийн жагсаалтад ороогүй, эсхүл нээлттэй өгөгдлийг нийтлэхээс өмнө хүн, хуулийн этгээдийн хүсэлтээр нээлттэй өгөгдлийг боловсруулж өгөх төлбөрийг тооцоход баримтална.

1.2.Энэ журмын 1.1-д заасан төлбөрийн хэмжээг энэ журмын 2.1-д заасан аргачлалд нийцүүлэн мэдээлэл хариуцагч тогтооно.

1.3.Мэдээлэл хариуцагч нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-д заасан этгээд байна.

1.4.Хүн, хуулийн этгээд нь нээлттэй өгөгдлийг цаасан хэлбэрээр авах хүсэлт гаргасан тохиолдолд холбогдох зардлыг нэмж төлнө.

1.5.Энэ аргачлалын 1.4-т заасан зардлын хэмжээг Засгийн газраас баталсан "Хүн, хуулийн этгээдэд цаасан хэлбэрээр нээлттэй өгөгдөл өгөхтэй холбогдон гарах зардал тооцох аргачлал, зардлыг төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам"-д заасан аргачлалын дагуу тооцно.

1.6.Нээлттэй өгөгдлийг цахим хэлбэрээр хүн, хуулийн этгээдэд өгөх тохиолдолд энэ журмын 1.4-т заасан зардлыг тооцохгүй.

Хоёр.Нээлттэй өгөгдлийн төлбөр тооцох аргачлал

2.1. Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдлийн төлбөрийг дараахь аргачлалын дагуу тооцно:

2.1.1.нээлттэй өгөгдлийг бий болгосон ажилтны ажлын цагийн хөлс, нээлттэй өгөгдлийг боловсруулж гаргахад зарцуулсан гүйцэтгэлийн хугацааг тодорхойлох;

2.1.2.ажлын цагийн хөлсийг тухайн ажилтны 1 өдрийн цалинг ажлын цагийн үргэлжлэх хугацаанд харьцуулсан дүнгээр тооцох бөгөөд дараахь томъёог ашиглана:

Ажлын цагийн хөлс = 1 өдрийн цалин/8 цаг (ажлын цагийн үргэлжлэх хугацаа)

Тайлбар: 1 өдрийн цалинг үндсэн цалингаас тооцно.

2.1.3.төлбөрийг тооцож гаргахдаа нээлттэй өгөгдлийг боловсруулж өгөхөд зарцуулах хугацааг ажлын цагийн хөлсөөр үржүүлэх бөгөөд дараахь томъёог ашиглана:

Төлбөр = Хугацаа*Ажлын цагийн хөлс

Тайлбар: Хугацаа-Нээлттэй өгөгдлийг боловсруулахад зарцуулсан хугацаа

Гурав.Бусад

3.1.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдөл боловсруулж өгөхтэй холбоотой төлбөр тооцох аргачлал, түүнийг төлөх данс бүхий мэдээллийг өөрийн цахим хуудас болон тухайн байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан байна.

3.2.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдөл авсан этгээдээс төлсөн төлбөрийг байгууллагын төсвийн урсгал санхүүжилтийн дансанд төвлөрүүлнэ.

3.3.Мэдээлэл хариуцагч хүн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг үндэслэн нээлттэй өгөгдлийг боловсруулж өгөх хугацаа 30 хоногоос илүүгүй байна.

---oOo---